



# МОНГОЛ УЛС

## Австралийн сургалтын тэтгэлэгт хөтөлбөрт өргөдөл гаргах

### Монгол дахь Австралийн сургалтын тэтгэлэгт хөтөлбөр

Австралиас Монголд үзүүлж буй олон улсын хөгжлийн тусламжийн хөтөлбөр хоёр тэргүүлэх чиглэлтэй. Үүнд:

- Хүний нөөцийн хөгжил
- Хөгжлийн төлөө уул уурхай зэрэг орно.

Монгол дахь Австралийн сургалтын тэтгэлэгт хөтөлбөр нь “Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулах иргэдийг чадавхижуулахын тулд хүний нөөц, манлайллын үндэс суурийг тавих” зорилготой.

Австралийн сургалтын тэтгэлэг бол хөгжлийн төлөө даян дэлхийн манлайлагчдын хойч үеийнхэнд Австралийн Засгийн газраас олгодог олон улсын нэр хүндтэй тэтгэлэг юм. Тэтгэлэг хүртэгчид сурч, судалгаа хийх замаар мэдлэг, ур чадвараа хөгжүүлж, өөрчлөлтийг удирдах болон Австралийн иргэдтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тусалдаг.

Өргөдөл гаргагчдыг сонгохдоо тэдний мэргэжлийн болон хувь хүний манлайлах чанарууд, академик чадамж, хамгийн чухал нь, Монгол Улсад тулгамдаж буй хөгжлийн сорилтуудыг шийдвэрлэхэд үзүүлж чадах үр нөлөөг харгалзан үнэлдэг.

Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах эрх эрэгтэй, эмэгтэй өргөдөл гаргагчдад адил тэгш үйлчлэх бөгөөд хөдөө орон нутгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд өргөдөл ирүүлэхийг дэмжинэ.

### Австралийн тэтгэлэгт хөтөлбөр: суралцах түвшин

Сургалтын тэтгэлэг нь Монгол Улсын иргэдийг Австралийн их сургуулиудад бакалаврын дараах түвшний боловсрол эзэмших боломж бүрдүүлдэг. Тэтгэлгийг хоёр ангиллаар олгодог. Үүнд:

**Ангилал 1:** Төв, орон нутгийн төрийн байгууллага, төрийн их, дээд, дунд сургууль, эмнэлэг, төрийн өмч давамгайлсан үйлдвэрийн газруудын албан хаагчид хандана. Тус ангилалд нийт тэтгэлгийн 55 хувийг олгоно.

**Ангилал 2:** Хувийн хэвшил, иргэний нийгэм ба ТББ-ууд, хувийн эрүүл мэнд, боловсролын байгууллагууд, хувийн хэвшлийн олон улсын байгууллагуудын Монгол дахь салбарын ажилтнууд хандана. Нийт тэтгэлгийн 45 хувийг энэ ангилалд олгоно.

Тэтгэлгийг Танхимын болон Судалгааны магистрын хөтөлбөрт дор дурдсан тэргүүлэх салбар, суралцах чиглэлээр олгоно.

### Тэргүүлэх салбарууд

2018 онд *Засаглал ба эдийн засгийн хөгжил; Байгалийн нөөц баялаг ба хүрээлэн буй орчин; Эрүүл мэнд, боловсрол ба нийгмийн үйлчилгээ; Дэд бүтэц, шинжлэх ухаан ба мэдээллийн технологи гэсэн* дөрвөн тэргүүлэх салбарыг тодорхойлсон.

### Суралцах болон мэргэших тэргүүлэх чиглэлүүд

2018 онд, дараах сургалтын чиглэлийг баримтална. Чиглэл тус бүрээр гаргасан мэргэшлийн жагсаалтад Монгол Улсад тэргүүлэх эрэлт хэрэгцээтэй ур чадвар, мэдлэгийг тусгасан.

Суралцах чиглэлүүд	Чиглэлүүдийн доторх нарийн мэргэшлүүд
<b>Төрийн албаны удирдлага</b>  <i>[Жич: Энэ суралцах чиглэл, мэргэших курсууд зөвхөн 1-р ангиллаар өргөдөл гаргагчдад хамаарна]</i>	Актуар судлал Хөрөнгийн удирдлага Аудит Худалдааны эрх зүй Бизнесийн засаглал Эконометрикс Эдийн засаг Хөдөлмөрийн харилцаа Шүүх нягтлан бодох бүртгэл Хүний нөөцийн удирдлага Олон улсын бизнес/ худалдаа Олон улсын эрх зүй Олон улсын харилцаа  Олон улсын худалдаа  Эрсдэлийн удирдлага  Стратегийн удирдлага
<b>Удирдлага, бизнес ба худалдаа</b>  <i>[Жич: Энэ суралцах чиглэл, мэргэших курсууд зөвхөн 2-р ангиллаар өргөдөл</i>	Актуар судлал Хөрөнгийн удирдлага Аудит Бизнесийн мэдээлэл зүй Худалдааны эрх зүй



<i>гаргагчдад хамаарна]</i>	Бизнесийн засаглал Эдийн засаг/эконометрикс Санхүү/Санхүүгийн удирдлага Шүүх нягтлан бодох бүртгэл Олон улсын бизнес/худалдаа Олон улсын эрх зүй Олон улсын худалдаа Хөдөлмөрийн зах зээлийн эдийн засаг Улс төрийн эдийн засаг Эрсдэлийн удирдлага Стратегийн удирдлага
<b>Боловсрол</b> <i>[Жич: Энэ суралцах чиглэл, мэргэших курсууд 1 ба 2-р ангиллаар өргөдөл гаргагчдад хамаарна]</i>	Боловсролын манлайлал Боловсролын удирдлага Боловсролын сэтгэл судлал Дээд боловсрол (суралцах тодорхой чиглэлийг өргөдөл гаргагч тодорхойлох)
<b>Инженерчлэл, уул уурхай, барилга хот байгуулалт</b> <i>[Жич: Энэ суралцах чиглэл, мэргэших курсууд 1 ба 2-р ангиллаар өргөдөл гаргагчдад хамаарна]</i>	Иргэний нисэх Дэд бүтцийн инженер Барилгын удирдлага Цахилгааны инженер Электроникийн инженер Байгаль орчны инженер Эрчим хүч/эрдэс баялгийн инженер Дэд бүтцийн хөгжил Ложистикийн удирдлага Материал судлал Материалын инженер Автын инженер Уул уурхайн инженер Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал Тээврийн инженер Тээврийн удирдлага Технологийн инженер Хот/бүс нутгийн төлөвлөлт
<b>Байгаль орчин, хөдөө аж ахуй судлал</b> <i>[Жич: Энэ суралцах чиглэл, мэргэших курсууд 1 ба 2-р ангиллаар өргөдөл гаргагчдад хамаарна]</i>	Хөдөө аж ахуй Хөдөө аж ахуйн бизнес Биотехнологи Эко-аялал жуулчлал Байгаль орчны боловсрол Байгаль орчны эрх зүй Байгаль орчны удирдлага Ойн удирдлага

	Геологи Газар зүйн мэдээллийн шинжлэх ухаан / технологи Геофизик Гидрогеологи Гидрологи Байгалийн нөөцийн удирдлага Сэргээгдэх эрчим хүч Тогтвортой хөгжил Орон нутгийн хөгжил Мал эмнэлгийн шинжлэх ухаан
<b>Эрүүл мэнд</b> <i>[Жич: Энэ суралцах чиглэл, мэргэших курсууд 1 ба 2-р ангиллаар өргөдөл гаргагчдад хамаарна]</i>	Эрүүл мэндийн удирдлага Сэтгэл судлал Нийгмийн эрүүл мэнд
<b>Мэдээлэл, харилцаа холбооны технологи</b> <i>[Жич: Энэ суралцах чиглэл, мэргэших курсууд 1 ба 2-р ангиллаар өргөдөл гаргагчдад хамаарна]</i>	Мэдээллийн удирдлага Мэдээллийн технологийн удирдлага Өмчийн эрх зүй Нанотехнологи
<b>Нийгэм, соёл ба хөгжил судлал</b> <i>[Жич: Энэ суралцах чиглэл, мэргэших курсууд 1 ба 2-р ангиллаар өргөдөл гаргагчдад хамаарна]</i>	Хөгжлийн бэрхшээл судлал Жендэр судлал Хүний эрх Олон улсын хөгжил Мэдээлэл, харилцаа холбоо Нийгмийн ажил, нийгмийн хамгаалал судлал

#### Австралийн сургалтын тэтгэлгийн үр шим

Австралийн сургалтын тэтгэлгийг Австралийн их сургуулиас санал болгосон академик хөтөлбөр, түүний дотор аливаа бэлтгэл сургалтыг дүүргэх хамгийн богино хугацааны туршид олгоно.

Сургалтын тэтгэлэг хүртэгчид дараах үр шимийг хүртэнэ. Үүнд:

- Австралид ирж, буцах онгоцны зардал
- Австралид очиж суурьших нэг удаагийн тэтгэмж
- Сургалтын бүрэн төлбөр
- Амьжиргааны зардал
- Академик сургалтын удиртгал хөтөлбөр
- Оюутан байх хугацааны эрүүл мэндийн даатгал
- Академик сургалтад олгох нэмэлт дэмжлэг
- Судалгааны ажлын зардал (зөвхөн судалгаа хийж буй оюутанд хамаарна).

## Болзол шалгуурууд

Австралийн тэтгэлэгт хөтөлбөрт өргөдөл гаргагчид <http://dfat.gov.au/about-us/publications/pages/australia-awards-scholarships-policy-handbook.aspx> холбоост байрлах “Австралийн сургалтын тэтгэлгийн бодлогын гарын авлага”-д дурдсан бүх ерөнхий шалгуурыг хангах ёстой.

Түүнчлэн тэтгэлэг горилогчид тухайн оронд тавигддаг тусгай шалгууруудыг хангах учиртай. Үүнд:

- Өргөдөл гаргагчид Монгол Улсын их, дээд сургуульд бакалаврын зэрэг эзэмшсэн бол дипломын голч оноо нь 3.0, түүнээс дээш, бусад оронд бакалаврын зэрэг дүүргэсэн бол тухайн боловсрол нь Австралийн их сургуулиудад хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.
- Улаанбаатар хотод ажиллаж, амьдардаг өргөдөл гаргагчид 2019 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар хүчинтэй Academic IELTS-ийн голч оноо 5.5-аас доошгүй (эсвэл TOEFL-ийн дүйцэх), нэгж оноо 5.0-аас доошгүй дүнтэй байна.
- Хөдөө орон нутагт ажиллаж, амьдарч байгаа өргөдөл гаргагчид 2019 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар хүчинтэй, Academic IELTS-ийн голч оноо 5.0-аас доошгүй (TOEFL-ийн дүйцэх), үүнээс унших, бичих ур чадварын оноо 5.0-аас доошгүй дүнтэй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ мэдүүлж, нотолсон өргөдөл гаргагчид 2019 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар хүчинтэй, Academic IELTS-ийн голч оноо 5.0-аас доошгүй (TOEFL-ийн дүйцэх), үүнээс унших, бичих ур чадварын оноо 5.0-аас доошгүй дүнтэй байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ мэдүүлж, нотолсон өргөдөл гаргагчдаас бусад бүх өргөдөл гаргагч 2018 оны 2 дугаар сарын 1-ний байдлаар, хоёр оос дээш жил тасралтгүй хөдөлмөр эрхэлсэн гэдгээ нотлоно (хүүхэд асрах чөлөөний хугацааг оруулж тооцно). 1-р ангиллаар өргөдөл гаргагчид 2018 оны 2 дугаар сарын 1-нээс өмнө төрийн албанд хоёр жил ажилласан байх шаардлагатай.
- Хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ мэдүүлж, нотолсон өргөдөл гаргагчдад хоёр жил тасралтгүй ажил эрхэлсэн байх шаардлага тавигдахгүй.

### Санамж:

- IELTS, TOEFL-ийн гэрчилгээ хоёр жил хүчинтэй байдаг. Иймд 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш шалгалт өгсөн байх ёстой.
- Австралийн тэтгэлэгт хөтөлбөрт зөвхөн Academic IELTS-ийн оноог хүлээн зөвшөөрнө. General IELTS-ийн шалгалтыг үл зөвшөөрнө.
- Зөвхөн цаасаар авдаг болон интернетэд суурилсан албан ёсны TOEFL-ийн тестийг хүлээн зөвшөөрнө. Institutional TOEFL-ийн оноог хүлээн зөвшөөрөхгүй.
- Өмнө нь гадаадад магистрын түвшний боловсрол эзэмшсэн өргөдөл гаргагч Австралийн сургалтын тэтгэлэгт ижил чиглэлээр өргөдөл гаргаж болохгүй.

## Онцгой нөхцөлүүд

Өргөдөл мэдүүлэгчид өргөдлийн маягтад шаардсан бүх мэдээллийг ирүүлнэ. Өргөдөлд худал мэдээлэл өгсөн, эсвэл тодорхой зүйлсийг үл мэдүүлсэн бол хууран мэхэлсэн гэж үзэх боломжтой.

Сургалтын тэтгэлгийн бодлогын гарын авлагын 3 дугаар хэсгийг үзнэ үү.

## Өргөдөл хүлээн авах хугацаа

**Эхлэх өдөр:** 2018 оны 2 дугаар сарын 1

**Дуусах өдөр:** 2018 оны 4 дүгээр сарын 30

Хугацаа хоцорсон өргөдөл, эсвэл дагалдах бичиг баримтыг хүчингүйд тооцно.

## Өргөдөл гаргах үйл явц

### Цахим өргөдөл

<https://oasis.dfat.gov.au> **цахим хуудсаар орж өргөдөл гаргана уу**

Өргөдөл гаргагчид дээр дурдсан хугацааны дотор цахим хэлбэрээр өргөдөл гаргана. Өргөдөл хаах хугацаа ойртох тутам Цахим өргөдлийн системийн (OASIS) ачаалал эрс нэмэгдэж, саатал учирч болзошгүйг анхаарна уу.

### Өргөдлийн хэвлэмэл хувь

Интернэт ашиглах боломжгүй аймаг, алслагдсан нутгаас өргөдөл гаргагчид Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн газартай холбогдож, өргөдөл гаргах хувилбаруудын талаар ярилцаарай.

## Бүрдүүлэх бичиг, баримтууд

Өргөдөл гаргагчид дараах бичиг, баримтыг бүрдүүлж, өргөдөлд хавсаргана.

Бичиг баримтын төрөл	Нотариатаар баталгаажуулах, эсэх
Төрсний гэрчилгээ (эх материалын хуулбар <b>ба</b> англи орчуулга)	Тийм
Монгол Улсын Иргэний үнэмлэх	Тийм
Дээд боловсролын гэрчилгээ (бакалавр, магистрын түвшин; эх материалын хуулбар <b>ба</b> англи орчуулга)	Тийм
Дипломын хавсралт (эх материалын хуулбар <b>ба</b> англи орчуулга)	Тийм
Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар (шимтгэл төлж, баталгаажуулсан) <b>эсвэл</b> 2016 оны 2 дугаар сарын 1-нээс 2018 оны 2	Тийм

дугаар сарын 1-ний хугацаанд ажилд томилсон тушаал <b>эсвэл</b> гэрээ	
IELTS <b>эсвэл</b> TOEFL-ийн гэрчилгээний хуулбар	Үгүй
Одоо хөдөлмөр эрхэлж буйг тодорхойлсон Ажил олгогчийн албан захидал (байгууллагын тамгатай монгол эх <b>ба англи орчуулга</b> )	Үгүй
Академик тодорхойлолт (тамгатай) <i>Судалгааны магистрын өргөдөл гаргагчид Академик байгууллага, эрдэмтний хоёр тодорхойлолт хавсаргана. Хэрэв тодорхойлолтууд монгол хэл дээр бол, англи орчуулга хэрэгтэй. Маягтын загварыг OASIS болон Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн цахим хуудаснаас татаж авна.</i>	Үгүй
Ажил байдлын тодорхойлолт (тамгатай). <i>Тодорхойлолтыг дээр дурдсан загварын дагуу бичнэ. Монгол хэлээр бол англи орчуулгыг хавсаргана.</i>	Үгүй
Товч намтар ( <i>англи хэлээр, сүүлийн 2 жилийн ажлын туршлагыг дэлгэрэнгүй</i> )	Үгүй
Буцаан байршуулах төлөвлөгөөг Хөтөлбөрийн цахим хуудсанд байрлуулсан маягтын дагуу бичнэ. Интернетэд холбогдох боломжгүй хөдөө, орон нутгийн өргөдөл гаргагчид Монгол дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн газартай холбогдоно уу.	Үгүй

## Сонгон шалгаруулах үйл явц

### Болзол хангасан эсэхийг баталгаажуулах

Өргөдөл хүлээн авах хугацаа дууссаны дараа өргөдөл тус бүр болзол шалгуур хангасан эсэхийг шалгаж, бичиг баримтын бүрдүүлэлт, нотариатаар баталгаажуулсан байдал /шаардсаны дагуу/, хүчинтэй эсэхийг нягтална. Сонгосон курсууд нь батлагдсан суралцах чиглэл, мэргэшилд нийцсэн үгүйг мөн тогтооно.

### Техник үнэлгээ

Болзол шалгуур хангасан өргөдлүүдийг хараат бусаар үнэлж, эрэмбэлэн, Монгол дахь Австралийн сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийн газарт ирүүлнэ.

## Хураангуй нэрсийн жагсаалт гаргах

Монгол, Австралийн төлөөллөөс бүрдсэн комисс хураангуй нэрсийн жагсаалтыг гаргана. Тус комисс Монгол, Австралийн Засгийн газруудын тэргүүлэх чиглэлүүдэд хамгийн сайн нийцсэн, академик сургалтад амжилт гаргах чадамжтай, бусдыг манлайлах ирээдүйтэй, Монгол Улсын хөгжилд тодорхой, бодитой хувь нэмэр оруулахаа харуулсан өргөдөл гаргагчдыг энэхүү жагсаалтад оруулна.

### Ярилцлага

Хураангуй жагсаалтад орсон бүх өргөдөл гаргагчтай ярилцлага хийнэ. Сонгон шалгаруулах комисс шалгуур үзүүлэлтүүдийг хамгийн сайн хангаж, Монгол Улсын хөгжилд бодитой хувь нэмэр оруулахаа харуулсан өргөдөл гаргагчдыг сонгож, зөвлөмж гаргана.

Зөвлөмжид багтах нэр дэвшигчдийн тоо тэтгэлэг горилогчдын чанар чансаа, Монголд олгох сургалтын тэтгэлгийн тооноос хамаарна. Тэтгэлэг хүртэх нэр дэвшигчдийг Австралийн Засгийн газар батлана.

### Австралийн сургалтын тэтгэлгийн санал

Тэтгэлэгт нэр дэвшигчид Австралийн сургалтын тэтгэлгийг хүртэхийн өмнө Австралийн их сургуулиас хуваарь авч, оюутны визний (эрүүл мэндийн) шаардлагуудыг бүрэн дүүрэн хангасан байна.

### Бэлтгэл сургалт

Тэтгэлэгт нэр дэвшигчид Австралийн их сургуулийн курсуудад элсэн орохын тулд англи хэлний шаардлага хангасан байна. Academic IELTS-ийн 6.5-аас доош голч оноотой (Official TOEFL-ийн дүйцэх оноотой) шалгарсан хүмүүс ажлаас бүрэн чөлөөлөгдөж Монголд 9 хүртэлх сарын англи хэлний сургалтанд зайлшгүй хамрагдана.

Academic IELTS-ийн 6.5-аас доошгүй оноотой (нэгж оноо 6.0-гаас доошгүй) хүмүүс Монголд Академик сургалтын хөтөлбөрт хамрагдана.

Тэтгэлэг хүртэгчид явахаасаа өмнө үдэлтийн өмнөх сургалтад оролцох ёстой.

### Сонгон шалгаруулалтын үр дүн

Сонгон шалгаруулалтын тодорхой шатанд тэнцээгүй хүмүүсийн өргөдлийг цаашид авч үзэхгүй гэдгийг цаг тухайд нь мэдээлнэ.

Ярилцлагад орсон нэр дэвшигчдийн дүнг 2018 оны 7-р сард сонгон шалгаруулалт дуусмагц мэдэгдэнэ.

## Дэлгэрэнгүй мэдээлэл

Австралийн сургалтын тэтгэлгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорхи холбоосоор орж үзнэ үү:

<http://australiaawards.gov.au/Pages/default.aspx>

Виз, Австралийн сургалтын тэтгэлгийн эрх үүрэг, нөхцөлүүдтэй холбоотой мэдээллийг Сургалтын

тэтгэлгийн бодлогын гарын авлагаас авч болно:

<http://dfat.gov.au/about-us/publications/pages/australia-awards-scholarships-policy-handbook.aspx>

Австралийн сургалтын тэтгэлэг болон Австралид суралцах талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаар орж үзээрэй:

[www.australiaawards.gov.au](http://www.australiaawards.gov.au)

[www.dfat.gov.au](http://www.dfat.gov.au)

<http://australiaawardsmongolia.org>

<http://cricos.education.gov.au/>

## Холбоо барих хаяг

Байгууллага: Монгол дахь Австралийн  
сургалтын тэтгэлэгт  
хөтөлбөр

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг

Б.Алтангэрэлийн гудамж 14200

Сити центр барилгын 702 тоот

Утас: +976-11-318852

Цахим шуудан: [info@australiaawardsmongolia.org](mailto:info@australiaawardsmongolia.org)

Цахим хуудас: <http://australiaawardsmongolia.org>